


Манай орны 6 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 12°C (53.6°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +18.1°C (64.6°F) –аас +25°C (77°F), бусад нутгаар 12.1°C –аас +18°C (53.8°F –аас 64.4°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 6 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 18 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 50.1-95 мм, говь-цөлийн бүс нутгаар 5-25 мм бусад нутгаар 25.1-50 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2024 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -0.1°C-аар хүйтэн, ОЖД-аас 0.9°C-аар дулаан байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 11 дэх дулаан сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн 55% нь ОЖД-аас +1.0–ээс +3.0°C-аар дулаан, 45% нь ОЖД-ийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 44.8 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 18.1%-иар, ОЖД-аас 46.6%-иар ахиу байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 24 дахь ахиу тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 43.4% нь дунджаас ахиу, 44.2% нь дунджаас бага, 12.4% -д ОЖД-ийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2024 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 6 дугаар сарын хоногийн дундаж агаарын температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) нийт нутгаар сарын ихэнх хугацаанд ОЖД-аас $+0.4$ -аас $+6.2^{\circ}\text{C}$ –аар дулаан, харин 2 дугаар 10 хоногийн эхэнд төв, зүүн, өмнө зүгийн нутгаар болон 3 дугаар 10 хоногийн эхнээс дунд үе хүртэл нийт нутгаар ОЖД-аас -0.9 -өөс -6.5°C - аар хүйтэн байлаа. Хур тунадасны хувьд нийт нутгаар харьцангуй ахиу хур тунадастай ялангуй 2 болон 3 дугаар 10 хоногт төв ба зүүн нутгаар харьцангуй их хур тунадас оржээ.




Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Агаарын үнэмлэхүй их температур 30°C -ыг давж халсан өдөр Баянхонгорын Эхийнголд 27 өдөр, Говь-Алтайн Тооройд 20 өдөр, Өмнөговийн Ханбогд, Сайхан, Дорноговийн Хөвсгөл, Замын-Үүд 15-20 өдөр, бусад нутгаар 15-аас цөөн өдөр ажиглагджээ.



Зураг 4. 30°C -аас халуун өдрийн өдрийн тооны газарзүйн тархалт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 39.6°C , үнэмлэхүй бага утга Завханы Цэцэн-Уулд -2.5°C хүрч ажиглагдсан. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Төв аймгийн Баянчандманьд 68°C , үнэмлэхүй бага утга Завханы Цэцэн-Уул, Баян-Өлгийн Дөчинжилд -4°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Төв аймгийн Зуунмод суманд 21-ний өдөр 86.4 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 945.0гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 764.5гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Баянхонгорын Хориултад 33 м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд